



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/010/НА-СТА-ТТЗ**

Чингис хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Баярбаатар  
Утас: 99058696 Цахим хаяг: bayarbaatarkha@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

Асуудлыг онцолсон хэсэг.....	2
Аудитын гол асуудал .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>5</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>13</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>15</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 526  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Г Хязгаарлалттай дүгнэлт Г**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын 23,741.7 мянган төгрөг, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 11,966.0 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 15,049.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн 4,823.1 мянган төгрөг нийт 55,579.8 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

**Засаг дарга нь:** Төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрт орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сангийн оны эхний үлдэгдлийг дутуу төлөвлөсөн, галт зэвсгийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогуудын төлөвлөгөө тасарсан байна.

**Засаг даргын тамгын газар нь:** бараа үйлчилгээний бусад зардлаас буудлын хөлс төлсөн, цахим мэдээллийн самбарын үйлчилгээнд төсвийн хөрөнгийг үр ашиггүй зориулалт бусаар зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардал, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд зарцуулсан байна.

**Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь:** Шилэн самбарын үйлчилгээ, сумын ИТХ-ын төлөөлөгч нарт албан томилолт олгосон, байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

**Хоршоо хөгжүүлэх сан нь:** Сумын ХХС-аас олгосон зээл, зээлийн хүүг хугацаанд нь төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", МУ-ын ЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 2.3-т "Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал нь төлөөлөгчийн хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зардал, сонгогчдын дунд зохион байгуулах арга хэмжээнд шаардлагатай заал, танхимын түрээсийн зардал болон шуудан, холбоо, бичиг хэрэг, албан томилолт зэрэг урсгал зардал, урамшууллын зардлаас бүрдэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн орлогоос 604,411.0 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс 1,562,749.5 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгээс 653,853.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 480,493.0 мянган төгрөг нийт 3,321,507.1 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийн тодотголоор аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 222,036.9 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 207,124.0 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн орлогыг 86,879.0 мянган төгрөгөөр, урьд үлдэгдлийг 40,150.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,019,376.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн авч 2,587,735.4 мянган төгрөгийг зарцуулж, 171,439.3 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 146,050.6 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлснээс 114,212.5 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 31,838.1 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд нийт 35,548.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11,106.4 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 11,442.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 12,999.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Норовлин сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 11 дүгээр хуралдаанаар Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийн 92.0 хувийн гүйцэтгэлтэй “Үр дүн гарсан” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		913,253.87	1,193,432.72
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	541,547.98	614,806.04
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	239,316.41	288,733.77
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	128,389.48	251,992.90
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	4,000.00	37,900.00
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,972,149.58	3,269,168.97
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,972,149.58	3,269,168.97
8	1.2.2.02 Биет хөрөнгө		2,480,895.58	2,777,914.97
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	491,254.00	491,254.00
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		3,885,403.45	4,462,601.69
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.00	76,302.29
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.00	76,302.29
13	2.1.1.03 Өглөг		0.00	76,302.29
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,885,403.45	4,386,299.39
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,885,403.45	4,386,299.39
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		362,801.46	362,801.46
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		3,351,327.32	3,852,223.27
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		171,274.66	171,274.66
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		3,885,403.45	4,462,601.69

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		4,448,142.14	3,449,946.93
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		785,806.64	808,249.21
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		541,143.70	575,071.18
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		541,143.70	575,071.18
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		119,384.27	127,708.88
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		125,278.66	105,469.15
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,563,317.90	2,641,697.72
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.00	1,388,889.49
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,099,017.60	0.00
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,276,408.49	2,529,572.46
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		2,276,408.49	2,529,572.46
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,180,691.79	2,509,052.54
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		718,415.62	869,688.87
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		89,946.64	100,825.49
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		661,528.19	699,659.38
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		91,636.88	82,164.65
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		740.00	0.00
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		22,339.50	49,387.71
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		23,012.00	28,950.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		59,132.24	121,381.67
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		513,940.73	556,994.77
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		95,716.70	20,519.92
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,171,733.65	920,374.47
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		846,167.14	421,378.52
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-846,167.14	-421,378.52
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		1,325,566.51	498,995.95

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**
**/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,970,588.46	2,727,368.99
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	785,806.64	808,249.21
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	541,143.70	575,071.18
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	119,384.27	127,708.88
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	125,278.66	105,469.15
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,126.88	22,627.13
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	37,382.72	28,718.35
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	52,769.06	54,123.66
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,064.22	1,919,119.79
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	86,064.22	65,407.03
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.00	1,406,983.15
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	446,729.60
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,098,717.60	0.00
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,955,791.80	2,201,304.70
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,955,791.80	2,201,304.70
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,841,981.43	2,171,602.77
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,590.60	863,193.19
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,189.60	106,904.72
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	661,528.19	699,659.38
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	65,864.84	76,541.24
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,800.00	1,800.00
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	30,072.90	63,139.45
23	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	23,102.00	29,290.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,733.86	194,934.29
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	172,099.46	136,140.50
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,810.36	29,701.93
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,014,796.67	526,064.29
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	692,808.51	345,106.22
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	692,808.51	345,106.22
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	692,808.51	345,106.22
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-692,808.51	-345,106.22
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	619.47	107,700.00
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-619.47	-107,700.00
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	321,368.68	73,258.06
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	220,179.30	541,547.98
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	541,547.98	614,806.04

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,552,466.72		2,552,466.72
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,370.21		7,370.21
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,559,836.94		2,559,836.94
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,325,566.51		1,325,566.51
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,885,403.45		3,885,403.45
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,885,403.45		3,885,403.45
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,900.00		1,900.00
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,887,303.45		3,887,303.45
9	1.7 Тайлант үеийн үр дүн	498,995.95		498,995.95
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,386,299.39		4,386,299.39

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,498,732.20	2,661,098.44
2	3.1.01.1.1 Татварын орлого	680,290.00	808,249.21
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	483,560.00	575,071.18
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	483,560.00	575,071.18
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	340,000.00	401,759.63
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	62,000.00	65,419.75
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	80,000.00	105,611.79
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,560.00	2,280.00
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	91,300.00	127,708.88
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,500.00	13,810.38
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,800.00	2,100.00
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	80,000.00	111,798.50
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	105,430.00	105,469.15
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	30,000.00	22,627.13
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	3,000.00	3,806.04
16	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	15,000.00	2,700.89
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12,000.00	16,120.20
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	20,000.00	28,718.35
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	20,000.00	28,718.35
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	55,430.00	54,123.66
21	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	23,730.00	23,730.00
22	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	31,700.00	30,393.66
23	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,818,442.20	1,852,849.23
24	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	31,000.00	65,407.03
25	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	10,000.00	13,378.5
26	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	20,000.00	51,923.53
27	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	0.00	105.00
28	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.00	0.00
29	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,340,712.60	1,340,712.60
30	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,340,712.60	1,340,712.60
31	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	446,729.60	446,729.60
32	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	446,729.60	446,729.60
33	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	466,729.60	2,941,266.27
34	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	-245,497.20	2,488,460.05
35	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,292,567.80	2,121,108.23
36	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	921,329.50	863,193.19
37	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	439,911.00	433,952.06

38	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	336,450.20	344,864.33
39	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	32,600.00	28,849.27
40	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	22,368.30	22,323.27
41	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	90,000.00	33,204.25
42	3.1.01.2.1.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,651.40	106,904.72
43	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	77,668.20	70,749.62
44	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,248.80	9,063.20
45	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,624.40	4,496.80
46	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,624.40	4,597.10
47	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	18,485.60	17,998.00
48	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	760,280.60	699,659.38
49	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	128,820.60	95,365.23
50	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	621,252.00	603,497.71
51	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	10,208.00	796.44
52	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	77,664.80	69,640.59
53	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	9,050.70	7,720.60
54	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	58,386.90	51,823.90
55	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,588.50	5,404.09
56	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,563.80	1,044.00
57	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,074.90	3,648.00
58	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,807.10	1,800.00
59	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807.10	1,800.00
60	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	67,198.90	57,391.81
61	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	15,105.80	15,085.00
62	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	943.00
63	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	51,150.00	41,363.81
64	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	31,289.00	29,290.00
65	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	31,289.00	29,290.00
66	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	214,110.1	193,354.29
67	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,293.20	188,454.17
68	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	0.00
69	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	2,514.30	2,400.00
70	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	1,536.40	715.72
71	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	220.00
72	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.40	1,564.40
73	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	963.50	0.00
74	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	104,236.40	99,874.25
75	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	92,795.50	90,074.40
76	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,440.90	9,799.85
77	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-2,538,065	367,351.82

78	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-2,542,646.50	363,425.82
79	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,000.00	9,999.92
80	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-2,552,646.50	353,425.90
81	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	4,581.50	3,926.00
82	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,581.50	3,926.00
83	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	602,226.80	345,106.22
84	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	602,226.80	345,106.22
85	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	110,000.00	107,700.00
86	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	110,000.00	107,700.00
87	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,032,002.60	-280,167.84
88	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-2,032,002.60	280,167.84
89	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2,032,002.60	280,167.84
90	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	541,547.98
91	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	614,806.04

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/мянган төгрөгөөр/**

Дансны код	Дансны нэр, төрөл	Аудитлагдсан дүн
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	66,270,554.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,270,554.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	66,270,554.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	66,270,554.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	66,270,554.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,270,554.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,149,542.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	55,149,542.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,494,542.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	6,900,651.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	6,900,651.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	5,747,638.00
210601	1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл	5,747,638.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,580,000.00
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,580,000.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	36,266,253.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	36,266,253.00
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,655,000.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	4,655,000.00
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,655,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	11,121,012.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(11,121,012.00)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(11,121,012.00)

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Норовлин сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сан, 3 тусгай сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС, ЭМТ-ийн санхүүгийн тайланд Ари файнэнс аудит ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

Сумын ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан болно.

**3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 146,050.6 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 114,212.5 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 31,838.1 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:**

#### Аудитын илрүүлэлт:

##### **Засаг даргын тамгын газар**

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас 6.4 сая төгрөгийг буудлын хөлсөнд төлж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Ажил гүйцэтгэх гэрээгээр цахим мэдээллийн самбарын үйлчилгээний зардалд 3.0 сая төгрөг зарцуулсан хэдий ч ашиглалт хангалтгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

3. Үндсэн үйл ажиллагааны зардлаас 4.0 сая төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 1.6 сая төгрөг, нийт 5.5 сая төгрөгийг биеийн тамир, спортын уралдаан тэмцээний зардалд зарцуулсан байна.

##### **Иргэдийн төлөөлөгчдийн хурал**

1. Коннект бридж ХХК-тай 2025 оны 2 дугаар сарын 26-нд 1 сарын хугацаатай “Норовлин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн шилэн самбар” ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 3.0 сая төгрөгийг бүрэн олгосон боловч одоог хүртэл дуусаагүй бүрэн ашиглалтгүй, хүлээлгэж өгөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” дэх заалтыг зөрчсөн байна.

2. Сумын ИТХ-ын төлөөлөгч нарт 7,200.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон нь Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” журмын 1 дэх заалтыг зөрчсөн байна.

3. Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15.1.8 дахь заалтыг зөрчсөн.

##### **Хоршоо хөгжүүлэх сан**

1. Сумын ХХС-аас санхүүжилт олгосон Цэтэн бүл хоршоо 2025 оны зээл, зээлийн хүүг хугацаанд нь төлөөгүй хугацаа хэтрүүлсэн.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 7 албан шаардлага хүргүүлсэн.

3.2. Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 77,653.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 67,791.3 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 9,321.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 540.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

**Ерөнхий боловсролын сургууль**

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүй 16 ажилтанд 15-25 хувиар тооцож, ур чадварын нэмэгдэл олгосон байна.

2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлсэн.

**Цэцэрлэг**

1. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, аудитын дүгнэлт өөрчлөлтгүй, 2024 оны төлөвлөгөөний биелэлт 97.0 хувиар үнэлэгдсэн үзүүлэлтээр цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тооцож 1,102.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байгаа

3. Ур чадварын нэмэгдлийг хагас жил дутамд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, нотлох баримтгүй, амжилтын түвшний хувийг 2 ажилтанд илүү тооцож 540.8 мянган төгрөг олгосон.

4. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 20 нэр төрлийн (анхны өртөг 22,169.3 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлсэн.

**Соёлын төв**

1. Тусон гэгээ ХХК-тай ном худалдан авах гэрээ байгуулан 5.0 сая төгрөгийг төлбөрийг шилжүүлэн авлагаар тусгасан боловч тооцоо нийлээгүй, тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлсэн.

**Эрүүл мэндийн төв**

1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлсэн.

3.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийцлийн аудитын асуудлаар хүргүүлсэн 1 зөвлөмжийг энэ тайлангийн 4.4.1-т тусгасан болно.

**3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 35,548.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11,106.4 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 24,441.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.**

### 3.3.1 Алдаа

1. Замд яваа мөнгө 11,106.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг залруулсан.

### 3.3.2 Албан шаардлага:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 11,042.6 мянган төгрөгийг, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс 400.0 мянган төгрөг нийт 11,442.6 мянган төгрөгийг дутуу төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 3.3.3 Зөвлөмж

1. Тайлант онд галт зэвсгийн орлого 700.0 мянган төгрөг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 12,299.1 мянган төгрөгөөр нийт 12,999.1 мянган төгрөгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	6,622.62			1	6,622.62	1	6,622.62				
ОНХС	1	107,589.90	1	107,589.9			1	107,589.9				
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>114,212.52</b>	<b>1</b>	<b>107,589.90</b>	<b>1</b>	<b>6,622.62</b>	<b>2</b>	<b>114,212.52</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
ЭМТ	2	37,438.00			2	37,438.00	2	37,438.00				
ЕБС	1	25,489.00			1	25,489.00	1	25,489.00				
Цэцэрлэг	3	4,864.33			3	4,864.33	3	4,864.33				
<b>УТБ-ын дүн</b>	<b>6</b>	<b>67,791.33</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>67,791.33</b>	<b>6</b>	<b>67,791.33</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
Засаг дарга	1	11,106.39	1	11,106.39			1	11,106.39				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>1</b>	<b>11,106.39</b>	<b>1</b>	<b>11,106.39</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>11,106.39</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>193,110.24</b>	<b>2</b>	<b>118,696.29</b>	<b>7</b>	<b>74,413.95</b>	<b>9</b>	<b>193,110.24</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	3	11,966.00			3	11,966.00						
ЗДТГ	3	15,049.00			3	15,049.00						
ХХС	1	4,823.06			1	4,823.06						
<b>ОНБ-ын дүн</b>	<b>7</b>	<b>31,838.06</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>31,838.06</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
Соёлын төв	1	5,000.00			1	5,000.00						
ЕБС	2	3,218.83			2	3,218.83						
Цэцэрлэг	4	1,643.15	1	540.80	2	1,102.35	1					
ЭМТ	1				1							
<b>УТБ-ын дүн</b>	<b>8</b>	<b>9,861.98</b>	<b>1</b>	<b>540.80</b>	<b>5</b>	<b>9,321.18</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
Засаг дарга	2	24,441.67			1	11,442.56	1	12,999.11				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>2</b>	<b>24,441.67</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>11,442.56</b>	<b>1</b>	<b>12,999.11</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>17</b>	<b>66,141.71</b>	<b>1</b>	<b>540.80</b>	<b>14</b>	<b>52,601.80</b>	<b>2</b>	<b>12,999.11</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЭМТ	1						1	
<b>УТБ-ын дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 283-А 2370456  
ХЭА-2026/010/НА-СТА-ТТЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн 11,042,564.00 (арван нэгэн сая дөчин хоёр мянга таван зуун жаран дөрвөн) төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 400,000.00 (дөрвөн зуун мянган) төгрөг, нийт 11,442,564.00 (арван нэгэн сая дөрвөн зуун дөчин хоёр мянга таван зуун жаран дөрвөн) төгрөгийн урьд оны үлдэгдлийг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тусган төлөвлөөгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг арилган биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Ө.Даваажаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Х.БАЯРБААТАР